

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ НАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны гуравдугаар сарын 04-ний 09 цаг 10 минутад эхэлж, 09 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 40 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.4, 3.7.1, 3.7.4 Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.1, 5.2, 6.1, 6.2, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4.5, 4.6, 4.7, 4.11 дэх хэсгийг тус тус баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар батлах</li><li>2. Салбар зөвлөлүүдээс 2015 оны үйл ажиллагаагаараа тэргүүлсэн Сэлэнгэ, Өмнөговь, Орхон аймаг дахь салбар зөвлөлийг сайшааж, Төрийн албаны зөвлөлийн “Батламж” олгох</li><li>3. Үйл ажиллагаа нь 70 хувиас доош хувьтай үнэлэгдсэн салбар зөвлөлүүд дүгнэлт хийж, ажил сайжруулах тодорхой арга хэмжээ авахыг Салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгох</li></ol>

		<p>4. Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааг дүгнээд, ажил сайжруулах асуудлаар Төрийн албаны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн тайлангийн хамт ирүүлэхийг нийт Салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 02 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд Баян-Өлгий аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баян-Өлгий аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 19 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх</li> <li>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</li> <li>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 3 нэр</li> </ol>

		<p>дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл /Т.Манкей/-д үүрэг болгох</p> <p>4. Үйл ажиллагааны ил тод байдал"-ыг хангах үүднээс шалгалтын явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан, харах боломжийг бүрдүүлж ажиллаагүй Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн дарга Т.Манкейд үүрэг болгох</p> <p>5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	---

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА